



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/182.

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40.1, Төсвийн тухай хуулийн 16.5.1, 16.5.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын “Хөдөлмөрийн дотоод журам” шинэчилэн батлагдсантай холбогдуулан “Ажлын цагийн бүртгэл, цаг ашиглалтад хяналт тавих журам” боловсруулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, “Албан томилолтоор ажиллах журам” боловсруулах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Шилдэг хамт олон”, “Шилдэг ажилтан” шалгаруулах арга, аргачлал боловсруулах ажлыг Захиргаа, удирдлагын газрын сургалт, олон нийт, хэвлэл мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Ч.Очирмаа)-д даалгасугай.

3. Дээрх журмын төслийг 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн дотор боловсруулж, батлуулахыг ажлын хэсгийн ахлагч, мэргэжилтэнд үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т даалгасугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2022 оны
..... дүгээр сарын 28-ны өдрийн
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

“АЖЛЫН ЦАГИЙН БҮРТГЭЛ, ЦАГ АШИГЛАЛТАД ХЯНАЛТ ТАВИХ
ЖУРАМ” БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Л.Мягмардорж Дотоод аудит, үнэлгээний асуудал
хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Б.Зоригтбаатар Байгууллагын дотоод сүлжээний
асуудал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Н.Уянга Хүний нөөцийн асуудал хариуцсан
ахлах мэргэжилтэн

--ooOOoo--

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2022 оны
..... дүгээр сарын 26-ны өдрийн
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**“АЛБАН ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ ЖУРАМ”
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

У.Дөшбат

Эм биобэлдмэлийн хяналтын улсын
байцаагч

Гишүүд:

Б.Санж-Очир

Орон нутгийн эрүүл мэндийн
байгууллагын эмнэлгийн тоног
төхөөрөмжийн шалгалт, тохируулгын
асуудал хариуцсан мэргэжилтэн

Г.Хулан

Эм, эмнэлгийн хэргслийн худалдан авах
ажиллагааны асуудал хариуцсан
мэргэжилтэн

Д.Ганчимэг

Хуурамч, стандарт бус эмийн тандалт,
судалгааны асуудал хариуцсан
мэргэжилтэн

Б.Оюундарь

Эм биобэлдмэлийн хяналтын улсын
байцаагч

Нарийн бичгийн дарга:

Б.Тэмүүлэн

Гадаад хамтын ажиллагаа, гэрээний
асуудал хариуцсан мэргэжилтэн

--ooOOoo--